



А.БАТБААТАР

Их Засаг Их сургууль
Хууль зүйн сургуулийн
Клиник сургалтын төвийн
эрхлэгч, докторант

ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Удиртгал:

Сэдвийг сонгон судлах болсон үндэслэл:

Олон ургалч үзлийг дээдэлж Монгол Улсад хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгож хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгосноор даруй 20 жилийн нүүрийг үзэж байгаа хэдий ч гэр бүлийн эрх зүйн зохицуулалт түүнийг дагасан маш олон асуудлууд ундарсаар л байна. Энэ нь мэдээж одоогийн дагаж мөрдөгдөж байгаа гэр бүлийн тухай хуультай салшгүй холбоотой юм. Учир нь цаг минутаар даяаршин өөрчлөгдөж байгаа өнөөгийн нийгэмд гэр бүлийн чиг хандлага нийгмээ дагаад даруй хувьсан өөрчлөгдсөөр л байна. Энэхүү хувьсан өөрчлөгдөж байгаа гэр бүлийн өөрчлөлтөд өнөөгийн дагаж мөрдөгдөж байгаа 1999 оны гэр бүлийн тухай хууль нь батлагдан гарснаас хойш ямар ч нэмэлт өөрчлөлт оролгүйгээр 10 гаруй жилийн нүүрийг үзэж байгаатай салшгүй холбоотой юм.

Учир нь гэр бүлүүдэд дараахь асуудлууд тулгамдсаар л байна. Үүнд: гэрлэлт цуцлалт тоогоо алдаж, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо ихсэж,

дагавар хүүхдүүд тоогоо алдаж, гадаадын харьяат иргэдээс хүүхэдтэй хоцрох эмэгтэйчүүд түүнийг даган хөх толботой Монгол гентэй хүүхдүүд гарах нь багасаж үндэсний эмгэнэл гэлтэй болж улмаар гэр бүлтэй холбоотой шүүхээр шийдэгдэж байгаа маргаантай асуудлуудын тоон үзүүлэлт ихэссээр байгаа нь гэр бүлийн тухай Монгол Улсын хууль нь зохицуулалтын болон хамгаалалтын чиг үүргээ гүйцэтгэж чадахгүй байгаатай салшгүй холбоотой юм.

Ядаж л нийгмээ дагаад эрх зүйн зохицуулалт хувьсан өөрчлөгдөж байдаг чиг хандлага гэр бүлийн эрх зүйг салбарт мартагдаад даруй 10 жил өнгөрч байна. Яагаад гэвэл нь энэ салбарт эрх зүйн зохицуулалт нь анхнаасаа л дутмаг судалгаа муутай нийгмийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон эрх зүйн зохицуулалтыг суулгаж өгөөгүйтэй салшгүй холбоотой юм.

Ийм учраас нийгмийн эрэлт хэрэгцээ шаардлагыг хангаж чадахуйц эрх зүйн зохицуулалтыг бий болгох үүднээс энэхүү сэдвийг сонгон судлах болсон.

Илтгэлд дурдагдсан анхаарах шаардлагтай маш олон асуудлууд байгаа учир дээрх асуудлуудыг зохицуулах Монгол Улс дахь гэр бүлийн тогтвортой байдлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нийгмийн шаардлагаар энэхүү сэдвийг сонгон судлах болсон.

Судалгааны ажлын зорилго, зорилт

Монгол улс дахь гэр бүлийн эрх зүйн зохицуулалтаар гарсан ном, сурах бичиг, хууль, эрх зүйн актыг судлаж үзсэний үндсэн дээр өөрийн санал дүгнэлтийг дэвшүүлэх замаар одоо гарч байгаа гэрлэлт цуцлалтын шалтгаан нөхцөл холбогдох маргаантай асуудлуудыг зөв шийдвэрлэж улмаар гэр бүлийн тухай хуулинд шинжлэх

ухааны үндэслэлтэйгээр онолын болон практикийн ач холбогдолтой зарим асуудлыг нэмж оруулах нь орчин үеийн хуульч бидний өмнө тавигдаж байгаа нэгээхэн чухал зорилтын яахын аргагүй мөн билээ. Иймээс илтгэгч миний бие сэдвийн гол зорилгоо болгож дараахь зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

Гэр бүлийн харилцаан дахь онолын хэрэгжилт муутай тунхаглал төдий заалтуудыг харьцуулан судлан үзэж уг тулгуурлан өөрийн санал дүгнэлтийг дэвшүүлэх замаар гэр бүлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход оршино.

Судалгааны ажлын ач холбогдол

Монгол Улс дахь гэр бүлийн эрх зүйн зохицуулалтыг судлан үзсэнээр гэр бүлийн гишүүдийн эрх, ашиг сонирхол хангагдах, зөрчигдхөөс урьдчилан сэргийлэх гэр бүлийн хуулинд дүн шинжилгээ хийн судлан үзэж хэрэгжилт муутай тунхаглал төдий зохицуулалтыг боловсронгуй болгох ингэснээр Гэр бүлийн тухай Монгол Улсын хуулийн зорилт хангагдах чухал ач холбогдолтой юм.

2.1 Гэрлэлт, гэр бүлийн ойлголт

Гэрлэлт гэр бүл гэдэг эр эм хоёрын түр зуурын зугаа цэнгэл учрал тохиолдлын явдал бус харин хүний амьдралд тохиолдох биологи, нийгэм эдийн засаг ёс суртахууны нэгдмэл шинж чанрыг агуулсан өвөрмөц онцгой холбоо юм. Иймээс Гэр бүлийн халуун дулаан орчинг бүрдүүлэхэд аз жаргалтай гэр бүл байхын тулд сүүлийн үед Монголд төдийгүй дэлхийн улс орон болгонд хань ижилээ сонгон судлах таних асуудал нь хамтын амьдралын үйл явц болж байна. Хамтран амьдарч бие биесээ танин мэддэг болсон тохиолдолд хууль ёсны дагуу

гэрлэлтээ бүртгүүлдэг хэв шинж нэгэнт тогтоод удаж байна.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 3.1.1-д “гэрлэлт” гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг хэлнэ.

Мөн хуулийн 3.1.2-д “гэр бүл” гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг” хэлнэ⁴¹. Гэр бүлийн хуулинд гэрлэхэд харшлах шалтгаангүй бол 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн нь гадаадын иргэнтэй харилцан зөвшилцсөнөөр гэрлэж болох талаар заасан бөгөөд гэрлэхэд харшлах шалтгаанд:

1. өмнөх гэрлэлт хүчинтэй байгаа бол;
2. гэрлэгчид хоёулаа, эсхүл хэн нэг нь 18 насанд хүрээгүй бол;
3. төрөл, садангийн хүмүүс хоорондоо гэрлэх;
4. харгалзан дэмжигч, дэмжүүлэгч хоёр гэрлэх;
5. үрчлэгч, үрчлүүлэгч хоёр гэрлэх;
6. гэрлэгчдийн хэн нэг нь эсхүл хоёулаа удамших; хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй бол⁴² гэж заасан нь гэрлэхэд тавигдах нилээд нарийн зохицуулалтыг гэр бүлийн тухай хуулинд тусгасан хэдийч гэр бүл цуцлахад эсрэгээр буюу тавигдах шаардлага нь хэт энгийн байдлаар эрх зүйн зохицуулалтыг тусгаж өгсөн байх юм.

⁴¹ Гэр бүлийн тухай хууль 1999 он

⁴² А.Батбаатар Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн зарим асуудал.,УБ 2007 он

2.2 Зарим улс орны гэр бүлийн эрх зүйн зохицуулалт

• Ихэнх улс орны хувьд гэрлэх нөхцлийг юуны өмнө тэдний нас гэж үздэг бөгөөд Жишээ нь: АНУ-ын зарим мужид эрэгтэй нь 21 нас хүрсэн. Испанид эмэгтэй 12 наснаас доошгүй гэх мэтээр заасан байна. Хаант Орос улсын үед эмэгтэй 12, эрэгтэй 15 сүүлд нь эмэгтэй 16, эрэгтэй 18 болж өөрчилсөн байна.⁴³

БНХАУ-ын 1980.09.10-ны өдрийн Ургийн буюу гэр бүлийн хуулинд зааснаар 20 нас хүрсэн эрэгтэй, 22 хүрсэн эмэгтэй, харин цөөнх үндэстний 20 нас хүрсэн эрэгтэй, 18 нас хүрсэн эмэгтэй гэрлэж болох/бусад оронтой харьцуулахад нас өндөр байгаа нь хүн амын хэт өсөлтийг шийдэх нэг арга.⁴⁴

ХБНГУ-ын хуулиар гэр бүлийн шүүх гэрлэгсдийн хүсэлтийг харгалзан тэдгээрийн аль нэг нь 18 насанд хүрсэн нөгөө нь 16 насанд хүрсэн нөхцөлд гэрлэхийг зөвшөөрдөг байна.⁴⁵

Ийнхүү хуулиар гэрлэгчдийн аль нэг нь заавал 18 насанд хүрсэн байхыг шаардаж байгаа нь гэрлэгчдийн аль нэг нь иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай байх нөхцлийг тодорхойлсон байна.

Италд насны хувьд Герман улстай адилхан байна. Харин Францад гэр бүлийн хууль нь 1990 онд батлагдсан 1997-2002 онуудад нэмэлт өөрчлөлт орж эрэгтэй 18, эмэгтэй 16 наснаас гэрлэж болно. Алжир, Танзани зэрэг улсын гэр бүлийн хууль нь 1954 онд батлагдсан Гэрлэх насыг хуулиндаа эрэгтэй 21 эмэгтэй 18, Польш,

эмэгтэй 18, эрэгтэй 21, Англид 16 насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй.

- Гэрлэх гол нөхцөлд мөн **цусан ба ясан ураг төрлийн** бус хүмүүс гэрлэх ёстой гэж хуулиндаа заасан байдаг Тухайлбал:

Францад ураг садангийн хүмүүс гэрлэж болохгүй, БНХАУ-д цусан төрөл ба 3 үеийн дотор гэрлэж болохгүй¹, Ирландад төрөл, удам гарлыг 28 үеэр гаргасан байна.

- Мөн гэрлэх гол нөхцөлд өөр хүнтэй албан ёсны гэрлэлтээ цуцлуулахгүйгээр гэрлэж болохгүйг ихэнх орны хуулиудад тодорхой заасан байдаг. Энэ нөхцөл нь **нэг нөхөр нэг эхнэртэйг** хуулчилсан хэрэг

1950 оны Хятадын ургийн хуулинд Эрэгтэй эсхүл эмэгтэй өмнөх гэрлэлт хүчинтэй байх үед гэрлэх буюу давхар гэрлэх 2 эхнэртэй байхыг хориглосон. БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 258 дугаар зүйлд давхар гэрлэсэн буюу өмнөх гэрлэлт хүчин төгөлдөр байгааг мэдсээр байж хамтран амьдарсан тохиолдолд 2 жил хүртлэх хугацаагаар хорих, хорьж хөдөлмөрлүүлэх ялыг сонгож хэрэглэнэ.⁴⁶

Солонгос улсын гэрлэлтийн хуулиар гэр бүлийн тогтвортой байдлыг алдагдуулсан тохиолдолд буруутай этгээдийг 3 сар хүртэлх хугацаагаар баривчлах ял шийтгэхээр заасан байна⁴⁷. Голландад ижил хүйстэй хүмүүсийн гэрлэлтийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байна.

- Харин зарим оронд **олон эхнэр, нөхөртэй** байхыг зөвшөөрдөг. тухайлбал

⁴³ Street low. UB.2003.23-page

⁴⁴ БНХАУ-ын гэр бүлийн хуулийн 2 дугаар зүйл.,Бээжин,1980 он

⁴⁵ В.В Залесский. Германское право.1996.стр.258.

⁴⁶ БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 256 дугаар зүйл.,Бээжин,1980 он

⁴⁷ Солонгос улсын гэр бүлийн хуулийн 18 дугаар зүйл

Пакистан улсад олон эхнэр, нөхөртэй байх нь шинээр гэрлэхэд ямар нэг саад болдоггүй байна. Энэ нь Мусульман шашны ёс жаягтай холбоотой юм. Мөн өмнөд Африкийн шашин нөлөөлсөн иргэд олон эхнэр нөхөртэй байж болохоор шүүхийн шийдвэр гаргаж байдаг¹. Турк улсын гэр бүлийн хууль 1973 онд батлагдсан ба уг хуулиар эрэгтэйчүүд 4 эхнэр авч болох, Морокко Улсын гэр бүлийн хуулиар эрэгтэй хүн 6 эхнэр авч болох тухай заасан байна.

2.3 Гэр бүлийн эрх зүйн харилцаанд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам

Судлаач миний зүгээс дараахь асуудлыг судлан үзэж анхаарлаа хандуулахыг зорьсон болно. /гэр бүлийн тухай хуулийн 2 дугаар бүлэг: Гэрлэлтийн харилцаа үүсэх үндэслэл, гэрлэх нөхцөл, журам, гэрлэлт дуусгавар болох/

Үүнд: гэр бүлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2-т...гэрлэгчид нь ...сэтгэл санааны хохирлоо буруутай этгээдээс гаргуулах эрхтэй... гэж заасан байдаг хэдий ч сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт, сэтгэлийн шанлалыг тооцох аргачлал байдаггүй учир дээрх заалт нь тунхаглал төдий оршсоор л байна.

Хавсралт: 1 Гэрлэгчид нь сэтгэл санааны хохирлоо буруутай этгээдээс гаргуулах эрхтэй... Гэрлэлт цуцлалтыг гэр бүл байсан хугацаагаар нь судлан үзвэл:⁵

Хамтран амьдарсан хугацаа	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Бүгд	815	650	688	884	1098	1622	1448	1757
1 жил хүртэл	30	25	35	29	41	62	30	48
1-3 жил хүртэл	112	91	85	104	123	146	135	143
4-6 жил хүртэл	185	138	127	155	213	241	196	279

7-9 жил хүртэл	170	152	114	201	213	274	260	387
10-аас дээш жил	318	244	327	395	508	899	827	900

Тийм ч учраас гэр бүлийн тухай хууль батлагдсанаас хойш нэг ч удаа сэтгэл санааны хохирлоо шаардан гаргуулсан тохиолдолд шүүхийн практикт алга байна. Гэтэл гэр бүлийн сөргөлдөөнөөс болж Тухайлбал: хүүхэд ганцаардан гутралд орох, хүчирхийлэлд өртөн шанлах, итгэл эвдсэнээс сэтгэл санаагаар унах зэрэг янз бүрийн шалтгаанаас болж гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд өмнөх 5-10 жилийн хөдөлмөр цаг хугацаа зүгээр л нэг гэнэтийн салхинд хийсэх тэр л үед сэтгэл санааны хүнд дарамтанд орж зарим нэг нь гомдол гутралаасаа болж амиа хорлосон тохиолдол гарсаар л байна.

10 дугаар зүйлийн 3. Гэрлэгчид нь бие биедээ үнэн ч байх үүрэгтэй...

Судалгаа: 2 Гэрлэгчид нь бие биедээ үнэнч байх үүрэгтэй.

Гэр бүл цуцлалтын шалтгаан	Тоо	Хувь
Залуус гэр бүлийн амьдралд бэлтгэгдээгүй	11	11%
Өндөр боловсролтой эмэгтэйчүүдэд бага боловсролтой эрэгтэйчүүд чамлагдах улмаар өрх тэргүүлсэн эмэгтэй байх уу, эсхүл гадаадын хүнтэй суух уу гэсэн сонголт идэвхижсэн	7	7%
Соёл уламжлалын дэвшилт бус хүчин зүйл идэвхижсэн	5	5%
Баян ядуугийн болон хот хөдөөгийн ялгаа ихэссэн	11	11%
Эцэг эх нь амьдралын хүмүүжил олгохоо больсон	13	13%
Нийгэмд салар самууныг сурталчилах, замбараагүй явдал газар авч улмаар шинэхэн гэрлэсэн эхнэр, нөхрүүд бие биеэ хууран мэхэлснээс болох	31	31%
Гэр бүлийн хүчирхийлэлээс болж	12	12%
Архидалтаас болж	10	10%

Гэр бүлийн хүрээнд болдог их бага зөрчил сөргөлдөөн нь өөрийн гэсэн шалтаг шалтгаантай бөгөөд энэ нь улмаар даамжирсаар маргаан болж шүүхээр шийдвэрлүүлдэг байна. Судалгаанаас харахад: итгэл эвдэж хууран мэхлэлтээс

болж гэрлэлт цуцлуулж байгаа шалтгаан нь 31 хувийг эзэлдэг байна. Гэтэл дээрх гэрлэгчидийг гэр бүлийг тогтвортой байлгах нэгээхэн чухал заалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх албадлагын арга хэмжээ огт байдаггүй. Уг нь албадлага гэхээсээ илүүтэйгээр гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, гэр бүл цуцлалтаас урьдчилан сэргийлэх өндөр ач холбогдолтой юм. Ялангуяа гэрлэлт цуцлалт тоогоо алдаж өдөр ахих тусам өсөн нэмэгдэж үндэсний эмгэнэл болоод байгаа өнөө үед дээрх заалтыг зөрчсөн тохиолдолд ядаж л дундын эд хөрөнгийн 80 хүртэл хувийг гэрлэлт цуцлуулахад буруутай байсан этгээдээс гаргуулах зохицуулалтыг хийж өгснөөр гэр бүл цуцлалтыг тоон үзүүлэлт багасаж улмаар гэр бүлийн үнэ цэнэ, тогтвортой байдал хадгалагдах юм.

14 дүгээр зүйлийн 2-т... 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж энэ хугацаанд гэрлэгчидийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авна.

Судалгаа: 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж энэ хугацаанд гэрлэгчидийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авна.

Он	Гэрлэлтээ цуцлуулсан хүний тоо	Эвлэрэх арга хэмжээ авагдсан хүний тоо	Эвлэрсэн хүний тоо
2008	1757	263	10
2009	1901	228	11
2010	2399	335	13
2011	3054	458	18
2012	3012	331	16

БЗДШүүх

Энэ нь нэг талаас гэрлэгчдийг болон гэр бүлийн гишүүдийн эрх, ашгийг хангахад чиглэгдсэн зөв зүйтэй арга хэмжээ болов ч харамсалтай нь шүүхээс хэргийг түдгэлзүүлсэн дээрх хугацаанд гэрлэгчдийг эвлэрүүлэх ямар нэгэн бодит арга хэмжээг авч ажиллахгүй байгаа нь хэргийг

сунжруулж үр нөлөө муутай болгож байна. Иймд эвлэрүүлэх хугацаанд гэр бүлийн тогтвортой амьдралд холбогдох гэр бүл сэтгэл зүйн хосолмол сургалт семинарыг зохион байгуулах гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн сургалтын арга хэмжээнд хамруулах уг арга хэмжээний үр нөлөөг дээшлүүлэхийн тулд хяналтын механизмыг бий болгох үр нөлөөтэй ажлыг зохион байгуулдаг төрийн болон төрийн бус байгууллагыг бий болгон хамтран ажиллах зайлшгүй шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл: ядаж л шүүгчийн захирамжинд эрх зүйн туслалцаа үзүүлэх төвийн сургалтанд хамрагдахаар тусгаж байх.

Гэрлэлт цуцлахад гэрлэгчид өөрсдөө шүүх хуралдаанд ирэх үүрэгтэй... ИХШХШ тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 1... **Гэрлэлт цуцлахад гэрлэгчид өөрсдөө шүүх хуралдаанд ирэх үүрэгтэй...**сүүлийн үед иргэд удаан хугацаагаар гадаадад гарч ажиллах тохиолдол эхнэр нөхрүүдтэйгээ холбоо барихгүй байх тохиолдол багагүй байна. Энэ тохиолдолд сураггүй алга болсон нас барсан гэж тооцуулж дараагын амьдралаа зохиох гэхээр өөрийн аав, ээж төрөл болон садангийн хүнтэйгээ байнга холбоотой байдаг. Гэтэл энд үлдсэн эхнэр, нөхрүүд нь өөр хүмүүстэй хамтран амьдарсан хэдий ч гэрлэлтээ бүртгүүлэх ямар ч боломжгүй ёстой л тэнгэр хол газар хатуу хуулийн зохицуулалт нь энэ гэж хүлээн эрх ашиг сонирхлоороо насаараа хохирох тохиолдолд байсаар л байна.

Мөн гадаадын иргэдтэй Монгол улсад гэрлэлтээ бүртгүүлсэн Монгол иргэд эх орондоо гэр бүлийн хүчирхийлэл болон янз бүрийн шалтгаанаар цугтан ирсэн тохиолдолд тухайн гадаад улсад амьдарч байгаа эхнэр, нөхөртэйгөө гэрлэлтээ цуцлуулах боломжгүй байсаар л байна.

Иймээс гадаадад гараад гэр бүлийн гишүүнтэйгээ холбоо барихгүй 3 жил өнгөрсөн тохиолдолд нотлох баримтыг үндэслэн гэрлэлтийг цуцалсанд тооцох эрх зүйн зохицуулалтыг тусгаж өгөх шаардлагатай байна.

Дээрх нь судалгаанаас харахад: Гэрлэлт цуцлалт жил бүр ихсэж залуужсан харагдаж байна. Иймээс гэрлэлт цуцлах шалтгаанууд янз бүрийн сэдэлттэй олон янз байгааг судалж үзэх шаардлагатай юм. Тухайлбал: хүнээс авсан.

Дүгнэлт:

Он	Гэрээгээр гадаадад амьдарч байгаа иргэдийн тоо	Эрэгтэйчүүдийн тоо	Эмэгтэйчүүдийн тоо
2004	20792	17092	3700
2007	18022	14890	3132
2010	8040	6038	2002
2012	46854	38020	8834
нийт			

Монгол Улсын гэр бүлийн тухай хууль нь зохицуулалтын болон хамгаалалтын чиг үүргээ хэрэгжүүлж чадахгүй байгаа өнөө үед гэр бүлийн тухай хуулийн зорилт бүрэн хангагдаж байна гэж үзэх үндэслэлгүй юм.

Иймэс дараахь зохицуулалтыг гэр бүлийн тухай хууль болон иргэний бүртгэлийн тухай хуулинд оруулж өгөх шаардлагатай байна.

Үүнд:

1. Гэр бүлийн тухай хуулийн 14.6 –д Шүүх хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах асуудлыг шийдвэрлэхдээ гэрлэгчдийн хэн нэг нь гэр бүл цуцлахад буруутай болон гэр бүлийн тухай хуулийн 10-р зүйлийн 3 дахь заалтыг зөрчсөн тохиолдолд буруутай этгээдийн өөрт ногдох дундын эд хөрөнгийн 80

хүртэл хувийг гэм хорын журмаар нөхөн гаргуулах эрхтэй

2. ИХШХШ тухай Монгол улсын хуулийн 132.1 эвлэрүүлэх арга хэмжээ авах захирамжинд эрх зүйн туслалцаа үзүүлэх төвийн сургалтанд хамруулахаар заах
3. Гэр бүлийн тухай хуулийн 14.3 –д гэрлэгчдийн хэн нэг нь гадаад улс оронлуу гарч эхнэр эсвэл нөхөрлүүгээ холбоо барихгүй 3 жил өнгөрсөн тохиолдолд холбогдох нотлох баримтыг үндэслэн гэрлэлтийг цуцалсанд тооцох.

Дээрх зохицуулалтыг хуулинд тусгаж өгснөөр дараахь ач холбогдолтой юм.

1. Монголын хүн ам зүйд тулгамдсан асуудал шийдэгдэхэд дөхөм үзүүлэх
2. Монгол генийн удмын сан хадгалагдаж улмаар ирээдүй хойч үеийн маань хууль ёсны эрх, ашиг сонирхол хангагдах.
3. Нийгмийн анхдагч нэгж болох гэр бүлийн үйл ажиллагаа тогтворжиж улмаар нийгэм, ирээдүй хойч үеийн амьдралын баталгаа нь бүрдэх.
4. Тогтвортой, баталгаатай гэр бүл нэмэгдэж улмаар нийгэм улс орны хөгжлийн үндэс суурь нь зөв тавигдаж, үндэсний аюулгүй байдалд бэхжигдэхэд чухал түлхэц өгөх юм.
5. Гэрлэгчид, гэр бүлийн гишүүдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол хангагдах улмаар Гэр бүлийн тухай Монгол Улсын хуулийн зорилт бүрэн хангагдах ач холбогдолтой юм.